

Урьд нь би Хинду шашинтай хүн байв. Миний ээж минь нэгэн христэд залбиралаар эдгэршгүй өвчнөөсөө эдгэрснээр Христэд итгэх болсон билээ. Тийнхүү түүний гайхамшигт эдгэрэл нь манай гэрийн бүх хүмүүст нөлөөлөн Христэд итгэх болсон боловч би Их Эзэнтэй дөрвөн жилийн өмнө л уулзсан билээ.

Хинди хэл дээрх Манмин Мэдээг уншиж ба Дели хотын Манмин Номлолын Төвтэй холбогдсон нь

1999 оны нэгэн өдөр манай гэрийн ойр хавьд нэгэн цуглааны үйл ажиллагаа явагдаж байлаа. Би тэр цуглаанд оролцдоггүй байсан боловч тэр цуглааны хажуу талд би амьдардаг байв. Тэр үед би тэдний магтаал дуг чимээгүйхэн сонсдог байв. Цуглааны үеэр сургаал айлдагч нь Библийн Исаиагийн нэгэн ишлэлийг уншиж байв. Тэр нь Исаиа 49:15. "Эх хүчүүд хүүхдээ мартаж чадах уу? Төрүүдсэн хөвгүүнээ энэрэхгүй байж чадах уу? Хэдийгээр тэр мартаж болох ч, Би чамайг мартахгүй." хэмээн дурдан бичсэн байдаг. Энэхүү ишлэл миний сэтгэлийг маш их хөдөлгөв. Эцэст нь би Их Эзэнийг хүлээн аван өмнөх амьдралдаа хийж байсан хиймэл шүтээн шүтэх явдал, архидалт болон шудрага бус байдлаар байснаа гэмшин залбирав. Мөн өмнөх амьдралынхаа хэв маягыг ч хойш тавьсан бөгөөд өдөр бүр би Бурхандаа залбиран Бурханы сургаалаар амьдрахыг хичээж байгаа Эзэний хайр ба нивэлээр миний амьдрал баялах болсон юм.

2009 оны Тавдугаар сард, Энэтхэг улсын Ассам мужын Гувахатид байрладаг ОМ номын дэлгүүрт явж очив. Тус номын дэлгүүрт тавьсан байсан Хинди хэл дээр хэвлэгдсэн Манмин Сүмийн Мэдээг уншаад маш их ивээлийг хүртсэн юм. Тэрхүү сонинд дор нь бичсэн байсан Делигийн Манмин Номлолын Төв дэх утасны дугаар дуу нь залгав. Ражу ах миний утасны дуудлагыг хүлээн авсан ба түүнээс хойш надад байнга Манмин Сүмийн Мэдээг явуулдаг болов. 'Бурханы Хүч Чадал' хэмээх нэртэй DVD-г ч бас явуулав.

# "Бурханы хүч чадал байхад Сайн мэдээ тараах амархан"

Иошуа Сотун (Шиллонг, Мегхалая Энэтхэг Улс)



Сүнсээр хүч чадлаар миний дүүргэгдсэн байсан ба Бурханы хүч чадлыг бусадтай хуваалцах чин хүсэл эрмэлзэлтэй болсон юм.

2009 оны Долдугаар сард би Делигийн Манмин Номлолын Төвөөс надад Доктор И Жаерок пасторын номуудыг явуулахыг хүсэв. Загалмайн Үг, Итгэлийн Хэмжээ, Тэнгэрийн орон I ба II, Там болон Сэрэгтүн Израил хэмээх нийт олон номуудыг нь уншив. Тэдгээрийг уншисаны дараа ч сайн мэдээг улам ч хүчтэй тунхагладаг болов.

Ялангуяа би Загалмайн Үг номны авралын зам ба загалмай дээрх гүн нарийн утга учрыг болон Итгэлийн Хэмжээ хэмээх номны Их Эзэнийг дуриах талаар уриалан дуудсан зүйлс надад маш их таалагдав. Эдгээр нь миний урьд нь сонсож байгаагүй гайхамшигт сургаалууд байв.

Бурханы хүч чадлыг болон ариун сайн мэдээг Энэтхэгтэйгүүр Балба болон Бутанд ч хүртэл тунхаглав

2009 оны Арванхоёрдугаар сарын 22-нд, Энэтхэгийн Мегхалая Шиллонг мужын кабелийн телевизийн төвд очсон юм. Би тэдэнд 'Бурханы Хүч Чадал IV' хэмээх DVD-г өгөн олон нийтэд нэвтрүүлгээр цацуулахыг маш их хүсэж байсан ба үүнийг хийхийн тулд өөрийнхөө хөрөнгөө зориулахад бэлэн байв.

Машин дотроо би тэрхүү DVD-г байнга авч явж байсан ба

'Бурханы Хүч Чадал IV' хэмээх бичлэгийг ойрх хотууд болон сүмүүдэд үзүүлдэг байв. Хүмүүс Есүс Христийн загалмайн сайн мэдээнд сэтгэл хөдлөн баяртайгаар хүлээн авшагдаж байлаа. Мөн түүнчлэн, Доктор И Жаерок пасторын залбиралаар далайн шорвог усыг амтлаж цэвэр ус болгон хувиргасан Муаны амтат усыг би тэдэнд танилуулж байлаа. Итгэлээр хэрэглэсэн хүмүүсийн өвчин нь эдгээдэг агуу гайхамшигт ус юм.

Манмины сайн мэдээг тараахад зориулсан тусгай нэгэн өрөө миний гэрт байдаг. Миний тэр өрөөнд Манмин Сүмийн Мэдээ, Доктор И Жаерок пасторын номууд болон Муаны амтат ус байдаг. Түүнээсээ би хүссэн хүн болгонд тэднийг харамгүй өгдөг билээ.

2009 оны Арванхоёрдугаар сарын 23-нд, би 120 DVD-г Балба улс руу илгээв. Би эхнэрийнхээ төрсөн нутаг болох Бутанд сайн мэдээг тараав. Энэтхэгийн хойд хэсгээр болон Бангладешид амьдардаг хүмүүсийн омгийн хэл болох Касис хэмээх хэлээр Бурханы сургаалыг тэднтэй хуваалцахын тулд судаж байгаа билээ. Тэдгээр хүмүүсийн хүн амын тоо нь 1,360,000 орчим болж байгаа юм. Тэрхүү газар нутгийн хүмүүст зориулан гаргасан материалууд нь тэдний төрөл хэл дээр орчуулагдсан билээ. Мөн би MIS(Манмин олон улсын библийн сургууль) д орж сурашаж ариун сайн мэдээг улам өргөнөөр тараахыг хүсч байна.

Энэтхэгийн Ассам омгийн 100-аад гэр бүлүүд Христэд итгэсэн нь

Энэтхэгийн Ассам мужын Тезпура хэмээх тосгоны 20 настай Сунита Мирда хэмээх нэгэн эмэгтэй муу ёрын сүнсэнд эзэмдүүлээд бараг жил болов. Тэрбээр эд хогшилоо шидэж эвдэх болон аймшигтай авирлаж байдаг тул гэр бүлийнхэн нь түүнийг өрөөнд нь байлгаж асарч хандаж байв. Олон пасторууд түүнд залбирал хийж өгдөг боловч ямар ч тус нэмэж болсонгүй. Тэр үед түүний аав нь Манмин сүмийн тухай олж мэдээл Доктор И Жаерок пастораас охиндоо залбирал хийж өгөхийг хүсэв.

Энэ талаар би Иохан Ким пастор гуайд (Делигийн Манмин Номлолын Төвийн) дамжуулан хэлэв. Ким пастор Доктор И Жаерок пасторт дамжуулснаар Баасан гаригын оройны цуглаан үеэр тэр охины төлөө залбирал хийсэн юм. Гайхамшигтай нь тэр охин муу ёрын сүнснээс ангижран хэвийн байдалдаа эргэн орсон билээ.

Энэхүү гайхамшигт Бурханы үйлсийг хараад түүний гэр бүлийнхэн болон тосгоныхон нь Хинду шүтлэгээ орхин Христэд итгэхээр . Эхлээд 20-иод гэр бүлүүд нэгдэн орж байсан бол энэхүү гайхамшигт мэдээ нь тосгон даяар тараад нийт 100-аад гэр бүлүүд Эзэнийг хүлээн авсан юм. Яагаад гэвэл түүний аав нь тус тосгондоо маш нэр хүндтэй хүн байсан ба олон хамаатан садангууд нь бас ойр амьдарцгаадаг байсан тул маш хүчтэйгээр нөлөөлсөн билээ.



Хинди хэл дээрх Манмин Мэдээ

"Бурханы Хүч Чадал" хэмээх DVD ба Доктор И Жаерок пасторын Загалмайн үг болон Итгэлийн Хэмжээ хэмээх номууд нь миний сэтгэл зүрхэнд хүрсэн юм. Бурханы хүч чадлыг үзүүлсэн DVD-г болон Доктор И Жаерок пасторын залбирал бий болсон агуу гайхамшигуудыг үзээд миний бие нилэнхүүдээ цахилгаан гүйдэл гүйсэн мэт алмайран гайхашраа. Би Ариун

## "Энэтхэгийн Зүүн Хойд Хэсэгт Бурханы Сургаалыг Тунхагласаар" Иохан Ким Пастор (Энэтхэгийн Дели хотын Манмин Номлолын Төв)

Дели Манмин Номлолын Төв нь Энэтхэгийн орон даяарх болон хөрш зэргэлдээ улсуудын сүлжээгээр Доктор И Жаерок пасторын номууд болон Хинди хэл дээрх Манмин Мэдээ болон GCN хиймэл дагуулын сувгаар дамжуулан Христийн нэвтрүүлгийг тус тус цацдаг билээ.

Доктор И Жаерок пасторын номууд нь Энэтхэг даяар маш алдартай билээ. Энэтхэгийн Библи судлалын газрын менежер Филипп Пастор гуай олон мянгаад христэд номуудыг түгээсэн бөгөөд Тэрээр хэлэхдээ, Доктор И Жаерок пасторын бичсэн Загалмайн Үг шиг гайхамшигтай номтой тааралдаж байгааг хэмээн хэлж байв. Тэрбээр Хинду болон Сиксүүдэд Загалмайн Үг номыг уншицгаагаарай хэмээн уриалан дуудав.

Манмин Мэдээг бид Хинди хэл дээр хэвлэн гаргаад шуудангаар алслагдмал хол газруудад хүртэл түгээн явуулдаг. Ойролцоогоор 200-аад номын дэлгүүрүүд болон Христийн сүмүүд ойролцоогоор 1000-аад итгэгч ах дүүс минь шуудангаар тус хэвлэлүүдийг хүлээн авцгаадаг билээ.

Доктор И Жаерок пастораар дамжуулан илэрхийлэгдэж буй Бурханы гайхамшигт Манмин Мэдээгээс олж уншсан итгэгч ах эгч нар маань биднээс сургалт семинар болон гар алчуурын цуглааныг зохион явуулан хэмээн хүсэлт тавьдаг ба мөн түүнчлэн, GCN (Global Christian Network) нь 24 цагын

турш хиймэл дагуулаар дамжуулан Энэтхэгийн Зүүн Хойд хэсэгт цацаж нэвтрүүлдэг билээ.

Олон пастор номлогчид болон итгэгч Иошуа Сотун шиг итгэлийн ах эгч дүү нар Манмины ариун сайн мэдээгээр дэлхий дахиныг нэгтгэх үйлст идэвхитэй оролцдог болохыг дурдан хэлэхэд таатай байна. Бурхандаа бүхий л алдар ба талархлыг өргөн барьж байна.



Мөргөл	Цаг
Их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшх мөргөл	Ням гариг 13: 40
3-дахь өдрийн мөргөл	3 дахь өдөр 18: 00
5-дахь өдрийн мөргөл	5 дахь өдөр 22: 00
Хүүхдийн мөргөл	ням гариг 10: 30
Сурагч залуучуудын мөргөл	Хагас сайн өдөр 16: 30

Ангилал	Цаг	Удирдагч
Даниел үүрийн залбирал	Даваа-баасан 05: 00- 06: 00	Ш. Золзаяа (Том хүний баг хариуцагч)
Даниел өдрийн залбирал	Даваа- баасан 09: 00- 10: 00	П. Уртнасан (2Том хүний баг хариуцагч)
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18: 30- 20: 00	П. Батзориг (Чуулганы хариуцагч)

**Хаяг:** Баянзүрх дүүрэг, 13-р хороолол 6-р хороо, ой булан- 6 иргэний А.О.С

**Утас:** чуулганы- 5525-7637 чуулганы хариуцагч- П. Батзориг 917-0773

www.manmin.org  
www.manmintv.org

# Манмин Мэдээ

## 2011 оны Иерусалим дахь олон улсын номын үзэсгэлэн худалдаанд

### Загалмайн үг, Тэнгэрийн орон I ба II, Там болон Сэрэгтүн Израйл хэмээх Доктор И Жаерок пасторын сургаалт номууд тавигдсан нь



1 Родноу ТВ Доктор И Жаерок пасторын 23 орны хэл дээр хөрвүүлэн номуудыг сурталчилж байгаа нь 2 Иерусалим хотын Хотын Захирагч Нир Баркатад (Баруун талд) Крystal Форумын төлөөлөгч Пастор Даниел Рожан (Зүүн талд) Тэнгэрийн орон I хэмээх номыг гардуулан өгч байгаа нь 3 Тэнгэрийн орон I ба II номууд нь АНУ-ын Худалдааны Яамны номын танхимд тавигдсан байгаа нь 4 Киппатай Еврей Иерусалим 2009 Израйлын Олон Улсын Соёлын Фестивалыг Урим Хэвлэлийн байранд

2011 оны Хоёрдугаар сарын 20-ноос 6 өдрийн турш Израйлын нийслэл Иерусалим хотноо тус хотын нэрэмжит олон улсын номын 25-р үзэсгэлэн худалдаа Олон Улсын Соёлын Төвд болж өнгөрлөө. Тус номын үзэсгэлэн худалдаанд дээр Израилд түгээгдэж буй Доктор И Жаерок пасторын олон орны хэл дээр орчуулагдсан номууд тавигдсан бөгөөд яг энэхүү Олон Улсын Соёлын Төвд Доктор И Жаерок пастор хоёр жилийн өмнө Есүс Христ бол бидний Аврагч Мессиа хэмээн тунхаглан сургаал айлдсан ба мөн түүнчлэн өвчин эдгээх цуглаанаар дамжуулан олон гайхамшигт эдгэрлүүд илчлэгдсэнээр түүний сургаалийг хүчтэй бөгөөд үнэн болохыг нотолсон юм.

Урим Хэвлэлийн газар (www.utimbooks.com) тус үзэсгэлэн худалдаанд дээр Доктор И Жаерок пасторын Загалмайн үг, Тэнгэрийн орон I ба II, болон Миний Амьдрал Миний Итгэл I ба II хэмээх олон номууд тус үзэсгэлэн худалдаанд тавигдсан билээ. Эдгээр номууд нь Еврей, Араб, Орос болон Англи гэх мэт нийт 23 орны хэлүүдээр орчуулагдсан юм. Мөн түүнчлэн, Бурханы Израилчуудад хандан айлдсан, Түүний хүсэл зорилгыг агуулсан Сэрэгтүн Израйл хэмээх нэртэй ном

хүртэл орсон байв. Урим Хэвлэлийн Газраас гарган тавьсан үзэсгэлэнд оролцохоор Иудейн шүтлэгтэй хүмүүсээс гадна АНУ, Франц, Герман, Бельги, Швейцарь, Англи болон Тайван зэрэг дэлхийн олон орны хүмүүс хүрэлцэн ирцгээв. Доктор И Жаерок пасторын олон орны хэл дээр орчуулагдсан номууд нь олон түмний анхаарлыг их татаж байлаа. Ялангуяа Назарет, Хайфа, Ашдод, Бет Шеан, Тел Авив болон Иерусалимын Крystal Форум холбооны пасторууд Урим хэвлэлийн газраас гаргасан энэхүү Олон Улсын Номын Худалдааны үйл ажиллагааг хараад маш сэтгэл өндөртэйгөөр хүлээн авсан юм. Тэд нар Израйилчуудад эдгээр номууд ямар их хэрэгтэй гайхамшигтай номууд болох тухай онцлон дурьдацгааж байлаа. Нэгэн оролцогч Урим Хэвлэлийн үзэсгэлэн худалдаанаас англи дээр орчуулагдсан нэгэн номыг худалдан аваад дараагийн өдөр нь мөн англи хэл рүү хөрвүүлсэн бусад номуудыг авахаар ирэхдээ "Би тэр номыг өчигдөр оройноос өнөө өглөө хүртэл суугаад уншиж дуусгав" хэмээн хэлээд худалдан авсан юм. Мөн Тэнгэрийн орон I ба II номууд нь АНУ-ын Худалдааны Яамны номын танхимд тавигдсан байгаа нь онцлон

тэмдэглүүштэй явдал билээ. '2009 оны Иерусалим дахь Олон Улсын Израйлын Соёлын Фестивал' хэмээх DVD бичлэг нь Урим Хэвлэлийн үзэсгэлэнгийн газарт том дэлгэцнээ тавигдав. Энэхүү DVD нь тус үзэсгэлэн худалдаанд хүрэлцэн ирцгээсэн олон хүмүүсийн анхаарлыг ихэд татаж байсан ба тэдгээр хүмүүс хэлэхдээ, Доктор И

### Киншаса Манмин Сүмийн 4 жилийн ойн баярын үйл ажиллагаа

Хоёрдугаар сарын 20-нд Африкийн Конго Ардчилсан улсын Киншаса Манмин Сүмийн 4 жилийн ойн баярын үйл ажиллагаагаар болж өнгөрлөө. Тус ойн баярын үйл ажиллагаанд нийт 1,572 хүн хандан оролцсоон ба үйл ажиллагааны эхний хэсэгт Африкийн Нэгдсэн Ариун урсгалын Сүмийн Удирдагч Бишоп Доктор Чен Мёнох пастор сургаалыг айлдсан бөгөөд тус сүмийн Эрэгтэйчүүдийн баг болон, Хүүхдийн багийнхан тус үйл ажиллагааны хоёрдугаар хэсэгт зориулан тусгайлан засан тайзнаа дуу бүжиг урлагын тоглолт хийсэн билээ. Ялангуяа Залуучуудын багаас бэлтгэсэн гаргасан "Үрэлгэн Хүү" хэмээх нэртэй жүжигчилсэн тоглолтыг оролцогч олон халуун дотноор хүлээн авч үзэцгээсэн юм.



# Миний Итгэл

“Итгэл бол бидний найддаг зүйлсийн бодит байдал, харагдахгүй зүйлсийн баталгаа мөн. Учир нь урьдын хүмүүс түүгээр гэрчлэлийг хүлээн авсан аж. Бурханы үгээр ертөнц бүтээгдсэн бөгөөд тийнхүү харагдах зүйлс нь үзэгдэх зүйлсээс бий болгогдоогүйг бид итгэлээр ойлгодог” (Евреи 11:1-3).

Хэрв эрхэм та жинхэнэ итгэлтэй бол Тэнгэрийн орон болон Тамыг оршин гэдэгт итгэдэг бөгөөд Бурханы өмнө Түүний өгсөн үүрэг даалгаварыг итгэмжтэйгээр сахин гүйцэтгэх хэрэгтэй. Библид олон газар итгэлийг алттай зүйрлэсэн байдаг. Алт болон сүнсэлг итгэл хоёр нь хувиран өөрчлөгдөшгүй нийтлэг шинж чанартай юм. Эрхэм танд Бурханы таалалыг хүртэх алт мэт хувирашгүй ариун итгэл бий юу? Эсвэл алтаар бүрсэн төдий төмөр итгэл үү? Энэхүү сургаал нь эрхэм таны итгэлийн талаар гурван талаас нь тайлбарлах болно.

Нэгт, Эрхэм та амаа сайн сайхан зүйлээр дүүргэдэг үү? 2 Самуельн 11-р бүлэгт, Давид хаан Уриа хэмээх түүнд үнэнчээр зүтгэдэг итгэмжтэй хүнийг юунаас болж яагаад аласан тухай гардаг. Энэ үйлдэл нь түүнийг маш их бэрхшээл болон хүнд хэцүү зүйлстэй тулгаруулдаг. Түүний хүү Абсалом нь хаант улсын эрх мэдлийг булаан авдаг. Тиймээс Давид өөрийн хүүгээсэс дайжин зугтдаг бөгөөд Давидыг Бахурим хэмээх хотод хуралцан ирэхэд Саул омгийн Шимей гэгч нэгэн хүн хүрч ирэн түүнийг хараан зүхдэг.



Доктор И Жаерок Тэргүүн Пастор

Давид Шимейгийн тийнхүү өөрийг нь элдвээр харааж доромжлоход нь ч зүгээр өнгөрүүлсэн төдийгүй түүний шадар цэргүүд нь тэр хүнийг алах гэхэд нь болиулдаг. Яагаад гэвэл Давидад тохиолдож байгаа зүйлс нь Бурханаас ирж байгаа болон түүнийг энэ сорилтоор дамжуулан дасгалжуулж байгааг мэдэж байсан тул тэрбээр хүмүүст бурууг өгсөнгүй. Бурханы хийж байгаа зүйлд тэрбээр даруухнаар дуулгавартай даган мөрдсөн юм.

Шимей Саул омгийн хүн болох Герагын хүү байв. Саул хааныг нас барахад Шимей Саулын үхэлд Давидыг буруутган түүнийг сэтгэл зүрхэндээ уурлан бухимдаж явдаг байв. Давидыг хүнд бэрхшээлтэй тулгаран явж байхад нь Шимей тийнхүү бухимдал гомдлоо тийнхүү илэрхийлэн гаргасан билээ. Тэрбээр бүр уур хилэнгээ тэсгэлгүй гарган Давидыг хараан зүхэж элдэв муугаар гутаан доромжилдог. Өрөвдөн тусламж дэмжлэг үзүүлэх ёстой байтал тэрбээр бүр ч зовж шаналж байсан Давидад улам хүнд хэцүү нөхцөл байдлыг үүсгэн бий болгодог.

Итгэчдийн дунд заримдаа итгэл сайтай мэт хүмүүс байдаг боловч тэд сорилт болон, хүнд бэрх зүйлстэй тулгарах үед байнга тавгийтэн бухимддаг болохыг харж болно. Хэдий нөхцөл байдлад хүнд байсан ч гэсэн тэд өөрсдийгөө бодож бусдыг дундаж шүүж, мөн бусдад буруугаа тохон өөрийнх нь хүнд хэцүү байдал өөр бусад чин нэгнээс болсон мэт үйлдэл гаргадаг ба төлөв даруу байхын оронд эргэн тойрондоо ийм тавгүй уур амсгал бүрдүүлж атгаж муу үйлийг үйлдэж байдлыг харж болно.

Ингэж бат итгэлтэй гэж өөрсдийгөө боддог тэдгээр хүмүүс нь утгаа маш бага итгэлтэй байгаагаа илэрхийлж байгаа юм. Цаашлан хэлбэл, ингэж бусдыг хүнд нөхцөл байдал оруулан, мөн дүгнэн шүүж, эргэн тойрондоо ниймэрхүү зүйл үйлддэг мөртлөө өөрсдийгөө итгэл сайтай гэж андуурдаг хүмүүс харин ч итгэлтэй хэмээн хэлэгдэхээргүй хүмүүс байдаг. Эрхэм та чин үнэн итгэлтэй бол ямар ч хүнд нөхцөлд байсан гэсэн сайн сайхнаар ялан гарж чаддаг байх хэрэгтэй.

Хоёрт, бусдыг эрхэм та өөрийн амь шигээ хайрладаг уу?

Эш үзүүлэгч Елиша болон дагалдагч Паул нь Бурханы агуу гайхамшигт хүч чадлыг өөрсдийнхөө тухайн цаг үед үзүүлэн гаргасан билээ. Бурханы агуу гайхамшигт хүч чадлаар Сирийн цэргийн жанжин, уяман өвчтэй Нааманыг элгээж болон Шунем нутгын эмэгтэйн нас барсан хүүг нь Елиша амилуулсан билээ. Мөн түүнчлэн, түүний дайн дажин болон үхэл хагашалын таларх дурдан хэлсэн зөгнөл болгон нь тэрчлэн тохиолдсон билээ. Элдээр агуу гайхамшигуудыг биелүүлэх хүч чадалтай байсан нь тэрбээр агуу гайхамшигт эш үзүүлэгч Елига бүх амьдралынхаа туршид дагалдаж байсны үр дүнд сүнсэлг хүч чадлынх нь хэсэгхэнийг хүлээн авсан байсан юм.

Хэдий тэрбээр Бурханы агуу гайхамшигуудыг биелүүлж байсан боловч түүний зүрх сэтгэл нь Паулын зүрх сэтгэлээ харьцангуй өөр байсан юм. Түүнийг Иерихог орхин Бетел руу явж байхад олон залуу хөвгүүд түүнийг доолсон доромжилж байсан юм. Елиша тэрхүү доромжлолыг тэсэлгүй ЭЗЭНий

тохиолддог ба үүнээсээ болж улам их хүнд хэцүү нөхцөл байдлуудыг бий болгодог. Тэр үед та өөрийгөө Бурханд итгэдэг хэмээн хэлж чадахгүй.

Бурхан Өөрт нь итгэн найддаг болон ямар ч нөхцөл байдалд Түүнийг чин сэтгэлээсээ итгэн найдаж, дуулгавартай дагадаг сүнсэлг ажилчдыг үргэлж хайж байдаг. Тиймээс Бурханы таалалыг хүртэхийн тулд дээрх гурван зарчмыг дагасай хэмээн Их Эзэний нэр дээр залбиран гуйж байна.

## Товч Мэдээ



## Далайн шорвог усыг амтлаг цэвэр ус болгосоны 11 жилийн ойн баярын үйл ажиллагаа

2011 оны Гуравдугаар сарын 3-нд, Муан Манмин Сүмийнхэн Бурханы гайхамшигт хүч чадлаар далайн шорвог усыг амтлаг цэвэр ус болгон хувиргасны 11-н жилийн ойн баярын үйл ажиллагаа болж өнгөрлөө.

Тус ойн баярын үйл ажиллагаанд тухайн орон нутгын удирдлагууд болон олон зочид гийчид ирцгээсэн ба Муан Гун дүүргийн засаг дарга ноён Сео Самсук болон Манмин сүмийн маш олон итгэгчид оролцсон юм. Тус үйл ажиллагаанд И Мёёунг Пастор “Хайр” хэмээх сэдэвт сургаал айлдсан бөгөөд үүний дараа Манмин Төв Сүмийн Кристад Дуучид хамтлаг болон Сэрэм Солонгосын үндэсний хөгжмийн багуудын тоглолтууд тайзнаа тус тус тоглов.

## Сэбу Манмин Сүм үүсгэн байгуулагдан үйл ажиллагаагаа эхлэв

2011 оны Гуравдугаар сарын 6-нд, Пастор Сесетта Сунг 180 сүмийн гишүүдээс бүрдсэн Себу Манмин Сүм үүсгэн байгуулагдав. Тэдгээр сүмийн гишүүд зүрх сэтгэлээрээ хайраар нэгдэн магтан дуу, бүжгээр Бурханыг алдаршуулан магтаагааж байлаа. Тэд Манмин Төв Сүмийн Ням гаригын Эзэний өдрийн мөргөл цуглаан, Баасан гаригын оройны цуглаан болон Даниелын Залбиралын цагыг GCN (Global Christian Network) сансрын хиймэл дагуулын сувгаар дамжуулан хамт оролцдог юм.

Mongolian

## Манмин Мэдээ

Published by Манмин Төв Сүм

235-3 Гуро-Здонг, Гуро-гу, Сеул, 152-848 Солонгос Улс  
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-2818-7048  
http://www.manmin.org/english  
e-mail: manminministry@hotmail.com  
Нийтлүүлэгч: Жаерок Лее  
Редактор: Геумсун Вин

# Эрхэм Та амнаас гарч буй үгээсээ болгоомжилдог уу?



## Санаандгүй хэлсэн үгс үл зөвшөөрөгдөнө!

Хэлэх ёстой болон хэлж болохгүй үг гэж байдаг. Бид аливаа үгийг сонсож буй хүнээ бодож хэлж байх хэрэгтэй. Сургаалт Үгс 10:19-д, “Үг олшироход нүгэл зайлшгүй, Харин амаа захирдаг хүн мэргэн нэгэн юм.” хэмээн хэлсэн байдаг. Хэдий олон сайхан үг хэлж байгаа ч гэсэн хэтрүүлэн дэгээдүүлэн хэлэх нь сонсож буй хүндээ таагүй мэдрэмж төрүүлэх тохиолдол бий. Мөн түүнчлэн, хэдийгээр сайн санааны үүднээс хэллээ ч гэсэн буруугаар ойлгогдон бусдад буруу ойлголт төрүүлдэг болохыг харж болно.

Есүс Эзэн Матай 15:18-д, “Харин амнаас гарах зүйл зүрхнээс гарч, тэдгээр нь хүнийг бузарладаг.” мөн Матай 12:35-д, “Сайн хүн өөрийн сайн баялгаас сайныг гаргадаг, муу хүн өөрийн муу баялгаас мууг л гаргадаг.” хэмээн тус тус айлдсан байдаг. Хэдий эрхэм та биеэрээ гэм нүгэл үйлдээгүй ч гэсэн өөрийн бодол санаа болон хэл амаараа хэлэх үгээ анхаарахгүй бол Бурханаас хариулт болон ерөөл хүртэхдээ удаан байдаг гэдгийг эрхэм та ойлгож хэрэгтэй билээ.

Сургаалт Үгс 13:2-д, “Өөрийн амнаас гарах үр жимснээс хүн сайн сайхныг амсдаг.” хэмээн хэлсэн байдаг ба эрхэм та өөрийн амнаас гарч байгаа үг болгоноо цэгцэн хянаснаараа Бурханаас хариулт болон ерөөл хүртэхдээ хурдан байх болно.

Есүс Матай 12:36-д, “Би та нарт хэлье. Бодлогогүй хэлсэн үг бүрийнхээ төлөө хүмүүс шүүлтийн өдөр тайлагнах болно.” хэмээн айлдсныг санах хэрэгтэй билээ. Гэм нүгэл үйлдсэн байсан ч гэсэн чин сэтгэлээсээ гэмшин залбирвал уучлагдах боловч гол асуудал нь маш олон хүмүүс өөрсдийгөө ямар зүйлсийг хэлж байснаа мартдаг бөгөөд түүнийгээ эргээд тодорхой сайн санаагаагүй учраас юм.

Худал зүйл хэлэх нь өөрт ч өрөөл бусдад ч маш халтай байдаг зүйл юм. Таны хэлсэн худал үгийг хэн нэгэн хүн итгэнээс болж сэтгэл санаа, эд материалын болон итгэлийн амьдралын хувьд хүнд байдалд орох тохиолдол байдаг. Тиймээс худал хэлэх нь Бурханы өмнө маш том нүгэл юм. Ямар ч өчүүхэн зүйл байсан гэсэн худал хэлэхгүй нуухгүй байх хэрэгтэй.

Хүмүүс бусдад буруугаа тохохоор эсвэл ямар нэгэн шалтаг хайх, мөн хүнд байдалд орохгүйн тулд нуух хаах үүднээс тийнхүү худал ярих болон буруу хариулт өгдөг. Хэрв эрхэм та сэтгэл зүрхэндээ жинхэнэ итгэлтэй бол худал ярих ямар ч хүсэлгүй байх билээ. Ихэнхи хүмүүс бусдыг анхааралтай сайн сонсодоггүй тул ингэж худал болон буруу хариуцлагыг харж болно. Тиймээс, эрхэм та хэн нэгэнд худал хэлэхгүйн тулд бусдыг сайн сонсож ойлгож байх хэрэгтэй.

Бурханы хүүхдүүд нь ниймэрхүү хорон яриа, атаа жөтөө болон хий хоосон яриагаар хэрэглэхгүй байх хэрэгтэй. Үнэн бодит зүйлийг дэвэргэн, хий хоосон зүйлийг хоөргөн ярих нь зохистой явдал биш юм. Хэрв эрхэм та үргэлж тоглоом тохуу хийж хөнгөмсөг үг хэлж ярьж байвал хүмүүс танд итгэхэд хэцүү байх болно. Түүнчлэн удирдах хүмүүс тань эрхэм танд итгэж чадахгүй тул таныг чухал албанд томилохгүй байх зэрэг олон асуудлыг үүсэх магадлалтай байдаг. Тиймд Ефес 5:4-д, “Бузар булай болон мунхаг яриа, эсвэл тоглоом тохуу нь зохимжгүй. Харин оронд нь талархлаа өргө.” хэмээн хэлсэн байдаг.

## Энэрэл-хайрын Үгс!

Ефесын 4:29-д, “Та нарын амнаас ямар ч ялзарсан үг бүү гараг. Харин хэрэгтэй үед нь бусдыг босгон байгуулахын тулд зөвхөн тустай үг хэл. Тэгвэл энэ нь сонсож буй хүнд нигүүлслийг өгнө.” хэмээн дурдан хэлсэн байдаг. Бурханы хүүхдүүд бие биеэ өсөн дэвжихэд нь туслахын тулд нигүүлсэл ба хайрын үгээр бусдыгаа босгон байгуулах хэрэгтэй. Тэдгээр үгс нь Бурханы алдаршуулах төдийгүй бусдын зүрх сэтгэлд итгэл найдвар, ба амьдрал хайрласан байх хэрэгтэй. Тийм ч учраас эрхэм та ямар ч нөхцөл байдалд байсан ч гэсэн өөрийн хэлсэн ярьсан зүйлсээ хянан цэгнэх хэрэгтэй.

## Таны хир хэмжээнээс хэтэрсэн зүйлсийг амнаасаа бүү гарга!

Төлөв даруу хүн өөрийн хир хэмжээнээсээ хэтэрсэн зүйлсийг ер хэлдэггүй. Өөрөөр хэлбэл тэр хүн өөрийн хир хэмжээнээсээ хэтэрсэн зүйлийг хэлдэггүй учраас төлөв даруу байдалтай байдаг. Үүний эсрэг, омголон бардам хүн нь өөрийн хир

хэмжээнээсээ хэтэрсэн зүйлийг үргэлж хэлж байдаг. Жишээлбэл, бусдыг шүүмжилдэг, хараах болон бусдыг гутаан доромжилсон зүйлс хэлэх нь энэхүү ангилалд орох билээ. “Хэрв та хуулийг шүүвэл та хуулийг биелүүлэгч биш, харин шүүгч аж”. (Иаков 4:11-6). Бурханы агуу гайхамшигыг хийж гүйцэтгэж байгаа хүмүүсийг шүүмжилэх болон хараах нь Бурханы эсрэг зүйл хийж байгаагаар адил юм. Энэ нь том гэм нүгэлд тооцогддог билээ.

Гомдлох, хэдэрлэх болон уурлан уцаарлах нь мөн энэ ангилалд ордог билээ. Бурханы хүүхдүүд нь аймшигт тамын халуун галд мөнхөд шатан зовох байсан зовлонгоос Их Эзэн Есүс Христийн хайр ба нивлэлээр ангижран авралыг хүлээн аван Тэнгэрийн орон руу замчлагдаж байгаа билээ. Тийм ч учраас Бурханы хүүхдүүд бие биенээ дүгнэж шүүх болон элдвээр хараах, гомдоллох болон уурлаж уцаарлах нь хүртсэн энэрэл нивэл, авралаа мартаж харин ч үгүйсгэсэнтэй адил юм. Ухаантай хүн ямар ч нөхцөл байдалд Бурхандаа талархал алдрыг өргөж байдаг.

Үүнийг бид Бурханы ажлыг хийхдээ үргэлж санах хэрэгтэй. Төлөв даруу хүн нь ямар ч хүнд нөхцөлд байсан ч гэсэн Бурхандаа талархалыг өргөн Бурханы юу хий гэсэнг дуулгавартайгаар дагадаг. Бурхан тийм хүнд ямар нэг ажлыг даатгахад тэрээр маш талархал дотор гүйцэтгэдэг. Хэрв эрхэм танд Бурхан ямар нэг ажлыг даатгахад та “яагаад би заавал ийм зүйл хийх ёстой юм бэ?” хэмээн очүүхэн ч гэсэн тавгийгх сэтгэл байгаа бол та аль хэдийнээ зөвхөн өөрийн нөхцөлд байдлаа өмнөө тавьж байгаа асуудал хэрэг юм. Эзэний тэнгэр элч онгон Мариад жирэмсэн болох тухай хэлэхэд тэрбээр, “Эзэний шивэгчнийг харгуйн. Хэлсэн үсгийнхэнд тань дагуу надад биелэх болтугай гэхэд нь тэнгэр элч түүнийг орхин одлоо.” хэмээн хэлдэгийг харж болно. (Лук 1:38).

## Зөвхөн өөдрөг үг болон итгэлээ тунхагласан үг

Сургаалт Үгс 18:21-д, “Амь ба үхэл нь хэл ярианы хүчинд байдаг. Түүнд дуртай хүн эдгээрийн үр жимсийг хүртдэг.” хэмээн дурдсан байдаг. Эрхэм та өдөр тутмынхаа амьдралд сэтгэлд сөв хийлгэсэн үгнээс зайлсхийн үргэлж сэтгэл өөдрөг болгосон үг болон итгэлээ тунхагласан үгсийг хэлж байх хэрэгтэй. Өөдрөг бус үгс нь сонсож байгаа хүндээ муу нөлөөтэй байдаг ба сэтгэл санаагаар унагааж дарамт зовлонтой болгодог. Үүний эсрэг, өөдрөг үг нь сэтгэл санаанд урам болон эрч хүч болдог. Мөн өөдрөг сайхан үгс нь хүнийг урам зоригтойгоор ажил үйлсээ хийх эрч хүч болон өөртөө итгэх итгэлийг хайрладаг.

Залуу Давид аварга хүн Голиаттай тулалдаж байхдаа түүний тухай хорон муу үгс хэлэлгүй төлөв даруу байсаар байв. Тэрбээр Ариун библийн 1 Самуел 17:45-47-д дурдсан шиг агуу их хүчит Бурханыхаа өмнө итгэлээ тунхаглан Түүний нэрээр ойртон ирж буй аварга хүнтэй итгэлээрээ тулалдсан юм. Үүний эцэст, тэр аварга хүнийг дүүгүүр чулуугаар төгс ялсан билээ. Израйлучуд Канаан газар руу орохын тулд эхлээд 12 хүнийг тухайн газар нутгыг сайтар тануулахаар илгээдэг тэдгээр 12 тагнуулч хүрч ирэхдээ тэдний 10 нь тэрхүү газар нутгийн тухай хэлэхдээ өөдрөг бусаар хэлцгээхэд олон хүмүүсийн сэтгэл санаа нь унан, итгэлээ алдаж бүр Канаанчуудаас айж байсныг харж болно (Тооллого 13:31-33).Тиймээс өөдрөг бус үг нь итгэл багатай хүмүүсийн итгэлийг нь мохоох ба гэм нүгэлд болон буруу зам руу хөтөлгөдөн ороход нь нөлөөлдөг. Тийм ч учраас эрхэм та өөдрөг бус хорон муу үгс хэлж байсан бол чин сэтгэлээсээ гэмшин залбирх хэрэгтэй. Тэгвэл таны итгэлийн амьдрал өөрчлөгдөх болно.